# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТОГТООЛ

2023 оны 12 сарын 20 өдөр Дугаар 59 Хараат

Төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.10-д заасныг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арван гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах товыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд хүлээн авахаар тогтоосугай.

Хоёр. Төсөл хүлээн авах дээрх хугацааг сумын хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, иргэдийн олонход мэдэгдэж хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар болон баасан хэлбэрээр хүлээн авахыг хорооны дарга (Засаг даргын Тамгын газрын дарга)-д даалгасугай.

ДАРГА Т.ТҮМЭНДЭЛГЭР